

ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ

1. **Тэтгэлэгт хөтөлбөрийн удирдлага, санхүүжилт:** Тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүтэц нь Төслийн удирдах хороо, Үнэлгээний комисс, Нарийн бичиг гэсэн бүтэцтэй байна.

Төслийн Удирдах Хороо (ТУХ): Геотехникийн мэргэжилтний ур чадварыг хөгжүүлэх төслийн Төслийн Удирдах Хороо нь Оюу Толгой, Рио Тинто Монгол ХХК болон ШУТИС-ийн дунд уг тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлагыг хариуцан ажиллаж, судалгааны стратеги боловсруулах, жилийн төсвийг батлах, үнэлгээний комиссын гишүүдийг томилох, олон улсын уурхайн сургуулиудтай хийх хамтын ажиллагааг чиглүүлэх, судалгааны төслийн шалгаруулалтыг батлах, судалгааны үр дүнгийн тайлангийн үнэлгээг батлах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Үнэлгээний комисс нь судалгааны төслийн саналуудыг үнэлж, ТУХ-д санал болгох гол үүргийг гүйцэтгэнэ. Үнэлгээний комисс нь судалгааны төслийн саналыг үнэлж, сайжруулах саналыг боловсруулж, судалгааны үр дүн, үр нөлөөг үнэлэх үүргийг хүлээнэ.

Нарийн бичиг нь тэтгэлэгт хөтөлбөрийн зохион байгуулалт бичиг хэргийг хариуцах бөгөөд ШУТИС-ээс томилогдсон мэргэжилтэн байна. Тэтгэлэгт хөтөлбөрийн Нарийн бичиг нь хөтөлбөрийг зарлах, сонирхогчдыг мэдээллээр хангах, судалгааны төслийн саналыг хүлээн авч хянах, Төслийн удирдах хороо болон Үнэлгээний комиссын өмнөөс төслийн даргатай харилцах, Төслийн удирдах хороо болон Үнэлгээний комиссын хурлыг зохион байгуулах, судалгааны тайланг хянах, үнэлэх ажилд туслалх зэрэг үүргийг гүйцэтгэнэ. Нарийн бичгийн ажлын хөлсийг СТХ-өөс ШУТИС-д төлсөн шимтгэлээс тодорхой заалтаар төлнө.

2. **Мерит шалгаруулалтын зарчим, шалгуур үзүүлэлт:**

Судалгааны төслийн санал

Хөрөнгө оруулахуйц судалгаанаас бидний голчлон харах зүйл нь судалгааны асуулт, асуудлыг маш тодорхой тавьсан, судалгааны ач холбогдлыг тодорхойлсон, тохирох судалгааны арга замыг сонгосон байхыг харна. Судалгааны асуулт нь онолын асуудлаас аваад практик асуудлыг шийдэх олон янзын асуулт байж болох ч судалгааны үр дүн нь мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, тулгамдаж буй асуудлыг шийдэх бодит үр нөлөө үзүүлэхүйц судалгааны бүтээл байхыг чухалчлана.

Бүх судалгааны төслийн саналыг өргөдөл мэдүүлэгчийн нас хүйс, угсаа гарвалаас үл хамааран эрх тэгш нөхцлөөр үнэлнэ. Төслийн саналуудыг санхүүжилтийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу меритийн зарчмаар үнэлж, дүгнэнэ.

Төслийн удирдах хорооны гол зорилго нь санхүүжилтийн төсөвт багтаан аль болох олон үр өгөөжтэй төслийг санхүүжүүлэх явдал юм. Гэхдээ онцгой сайн төсөлд бусад төслөөс илүү санхүүжилт олгоно. Төслүүдийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- (a) Академик чанар/ мерит;
 - Төслийн саналын шинжлэх ухааны болон эрдэм судлалын чанар
 - Гол судлаачийн мэргэшсэн байдал, туршлага
 - Цэвэр өөрийн бүтээл байх
 - Төслийн хугацаанд хэрэгжүүлж болох магадлал
- (b) Судалгааны үйлдвэрлэлийн үр нөлөө, эдийн засгийн болон нийгмийн үр нөлөө
- (c) Академик болон мэргэжлийн хөгжилд оруулж буй хувь нэмэр

Комисс төслийн санал бүр дээр дараах 7 онооны балаар оноо өгнө.

Оноо	Үнэлгээний тайлбар
5	Үндэсний хэмжээнд эсвэл үйлдвэрлэлийн онцгой үр өгөөжтэй. Төслийн санал нь бүрэн дүүрэн нотолгоо бүхий учир холбогдлыг тодорхойлсон. Санхүүжилт олгох тэргүүлэх судалгаа гэж үзнэ.
4.5	Маш өндөр түвшний судалгааны стандартыг барьж боловсруулсан. Хүчтэй нотолгоо, учир холбогдол бүхий төслийн санал боловсруулсан. Санхүүжилт олгох тэргүүлэх судалгаанд тооцно.
4	Судалгааны стандартыг барьж боловсруулсан. Сайн нотолгоо, учир холбогдлыг харуулсан. Санхүүжилт олгоход авч үзнэ.
3.5	Судалгааны стандартыг сайн барьж боловсруулсан боловч санхүүжилт олгох тэргүүлэх судалгаанд төдийлөн тооцогдохгүй.
3	Хангалттай сайн чанартай боловч өрсөлдөхүйц түвшинд биш. Санхүүжилт олгохгүй.
2	Зарим нэг давуу тал, шинэлэг санаа байгаа боловч, сул дутагдалтай тал ихтэй. Санхүүжилт олгохгүй.
1	Маш олон сул тал дутагдалтай. Санхүүжилт олгохгүй.

3. Үнэлгээний комиссын бүрэлдэхүүн, үнэлээчдийг сонгох:

Үнэлгээний комиссын дарга нь уурхайн судалгаагаар мэргэшсэн ШУТИС-ээс бусад их сургуулийн нэр хүндтэй эрдэмтэн (гадаадын эксперт байж болно) байна. Комиссын дэд дарга нь Оюу Толгой, Рио Тинто Монгол ХХК-ийн төлөөлөл байх бөгөөд Комиссын дарга болон дэд дарга нь Төслийн удирдах хорооноос томилогдоно. Комиссын хамтарсан дарга нь комиссын гишүүнээр давхар ажиллана.

Жил бүр комиссын бүрэлдэхүүн өргөн болон нарийссан мэргэжлийн чиглэлийг тэнцвэртэй хадгалах байдлаар томилогдсон эсэхийг хянана. Үнэлгээний комисс нь дараах 7 гишүүнээс бүрдэнэ: Оюу толгой болон Рио Тинто Монгол ХХК-ийн ахлах инженер болон сургалтын менежерийн 3 төлөөлөл, ШУТИС-ээс бусад их дээд сургуулийн 4 доктор байна.

Төслийн удирдах хороо нь ШУТИС болон Оюу Толгойгоос жил бүр комиссын гишүүнээр ажиллахад тохиромжтой хүмүүсийг санал болгохыг урьж, жил бүр мерит зарчмаар гишүүдийг сонгож томилно. ШУТИС-д санал болгох гадаад экспертүүд байвал, Төслийн Удирдах Хороонд санал болгож болно.

Комиссын хамтарсан дарга нар Төслийн удирдах хороогоор бүрэлдэхүүнийг батлуулахаас өмнө гишүүнээр санал болгосон хүмүүст тохирох ур чадвар байгаа эсэхэд өөрсдийн дүгнэлтийг хийж танилцуулна. Төслийн Удирдах Хорооны томилгоо нь хүн бүрийг тусад нь авч үзэх бөгөөд Комиссын гишүүд нь ШУТИС-д албан тушаал эрхэлдэггүй байна.

4. Үнэлээчээр ажиллах мэдэгдэл

Комиссын гишүүдийг үнэлээчээр ажиллахыг анхлан томилсноос аваад дараа дараагийн жилийн томилгоонд комиссын гишүүд үнэлгээнд оролцох боломжтой байгаагаа Үнэлээчээр ажиллах маягт дээр бөглөж мэдүүлнэ. Уг маягтыг жил бүр шинээр бөглөж явах ба маягтыг Оюу Толгой Судалгааны Тэтгэлэгт Хөтөлбөрийн Нарийн бичиг хөтлөн явуулна. Комиссын гишүүдийг жил бүрийн 6 сард томилох бөгөөд томилгооноос хойш 7 хоногийн дотор оролцох мэдэгдлээ хүргүүлнэ. Комиссын гишүүд судалгааны төслийн саналыг үнэлэхдээ мөн Комиссын үнэлгээний хуралд оролцохдоо, өөрийн сургуулийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй. Аливаа нэг ашиг сонирхлын зөрчил гарахаас сэргийлж, хэрвээ Комиссын гишүүн тухайн төслийн санал мэдүүлэгчтэй ямар нэг байдлаар холбоотой байвал энэ асуудлыг Комиссын дарга болон Нарийн бичигт мэдэгдэж шийднэ.

5. **Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, шийдвэрлэх:** Энэ хэсэгт судалгааны төслийн саналыг үнэлэх явцад гарсан ашиг сонирхлыг Төслийн Удирдах Хорооны болон Үнэлгээний Комиссын гишүүд хэрхэн авч үзэх зааварчилгааг харуулна.

Ашиг сонирхлын зөрчлийн төрлүүд

Үндсэн ашиг сонирхлын зөрчил

Байгууллагатай холбоотой зөрчлүүд

- a) Өргөдөл мэдүүлэгчийн¹ ажилладаг байгууллагад одоо эсвэл сүүлийн хоёр жил ажилласан байх;
- b) Өргөдөл мэдүүлэгчийн байгууллагад цагаар, зочин профессороор эсвэл хүндэт профессороор ажилладаг байх;
- c) Өргөдөл мэдүүлэгчийн ажилладаг байгууллагын сургууль, тэнхимд зөвлөхөөр ажилладаг байх;

Өргөдөл мэдүүлэгчтэй холбоотой зөрчлүүд

- a) Үнэлгээний Комиссын гишүүн өөрөө өргөдөл мэдүүлэгчийн судалгааны төсөлд зохицуулагч, үндсэн судлаач, хамтарсан судлаач, туслах судлаач, хамтрагчаар оролцсон байх;
- b) Уг судалгааны төслийн саналыг урьдчилан хянаж, зөвлөсөн байх;
- c) Өргөдөл мэдүүлэгчтэй зөвлөхийн харилцаатай байх (докторантын удирдагч байх);
- d) Өргөдөл мэдүүлэгчтэй патент хамтран эзэмшдэг байх;
- e) Өргөдөл мэдүүлэгчтэй хувийн харилцаатай байх (жш. Хамтран амьдрагч, гэр бүлийн хүн, төрөл садан, урт хугацааны найз нөхөд байх);
- f) Сүүлийн 3 жилд өргөдөл мэдүүлэгчтэй хамтран эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн байх;
- g) Сүүлийн 3 жилд өргөдөл мэдүүлэгчтэй хамтран судалгааны төсөл хөтөлбөр дээр ажилласан байх;
- h) Хороо болон Комиссын гишүүний ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзсэн бусад тохиолдлууд.

¹ Нэг судлаачтай төсөлд, өргөдөл мэдүүлэгч нь Гол Судлаач. Судалгааны баг бол өргөдөл мэдүүлэгч нь бүх багийн гишүүдийг хэлнэ.

Бага зэргийн ашиг сонирхлын зөрчил

Дээрх үндсэн ашиг сонирхлоос гадна, комиссын гишүүний үнэлгээнд нөлөөлж болзошгүй гэж үзсэн бусад тохиолдлуудыг бага зэргийн ашиг сонирхол гэж үзнэ. Жишээ нь:

- a) Сүүлийн 3-7 жилийн хугацаанд өргөдөл мэдүүлэгчтэй хамтран эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлж байсан;
- b) Сүүлийн 3-7 жилд өргөдөл мэдүүлэгчтэй хамтран судалгааны төсөл хөтөлбөр дээр ажилласан байх;
- c) Сүүлийн 7 жилд өргөдөл мэдүүлэгчтэй хамтран томоохон ажлыг зохион байгуулж байсан;
- d) Хороо болон комиссын гишүүний ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзсэн бусад тохиолдлууд.

Авах арга хэмжээ

Үнэлгээний Комиссын гишүүн

Комиссын гишүүд нь байгууллага, өргөдөл мэдүүлэгчтэй холбоотой үндсэн ашиг сонирхолтойгоо мэдэгдсэн тохиолдолд үнэлгээнд оролцохгүй.

Бага зэргийн ашиг сонирхлын тухайд комиссын гишүүний үнэлгээнд ямар нөлөө үзүүлж болохыг тооцож үзсэний дараа шийдвэр гаргана.

- a) Бага зэргийн ашиг сонирхол бүхий өргөдлийг үнэлэх ажлаас тухайн гишүүнийг чөлөөлөх;

- b) Бага зэргийн ашиг сонирхол байгааг Хороо/Комисст мэдэгдсэн, гэхдээ энэ нь комиссын гишүүний үнэлгээнд нөлөөлөхгүй;
- c) Үнэлгээ дуусгавар болсны дараа бага зэргийн ашиг сонирхол бүхий өргөдөл мэдүүлэгчийн өргөдөлд өгсөн санал зөвлөмжийг тооцохгүй байх.

Үндсэн ашиг сонирхолтойгоо мэдэгдсэн гишүүн тухайн өргөдөлтэй холбоотой үнэлгээний бүх үйл явцад оролцохгүй.

Комиссын болон Хорооны дарга

Үнэлгээний Комисс болон Төслийн Удирдах Хорооны Дарга үндсэн ашиг сонирхолтойгоо мэдэгдсэн тохиолдолд өргөдлийг үнэлэх, шийдвэрлэх бүх үйл явцад оролцохгүй, тухайн өргөдлийг шийдвэрлэх даргын үүргээ өөр гишүүнийг томилон гүйцэтгүүлнэ.

Комисс болон Төслийн Удирдах Хорооны Дарга бага зэргийн ашиг сонирхол байгаагаа мэдэгдсэн бол, тухайн өргөдлийг үнэлэх, эцсийн дүгнэлт гаргахад өөрийнх нь оролцоо хэр байх талаар шийдвэр гаргасны үндсэн дээр өргөдлийг шийдвэрлэх үүргийг хүлээнэ.

Ашиг сонирхлыг бүртгүүлэх

Судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт оролцож буй гишүүд өөрсдийн ашиг сонирхолтой эсэхээ мэдэгдсэн бүртгэлийг Нарийн бичигт хадгалуулна. Өөрийн мэдэгдэлд орсон өөрчлөлт байвал Нарийн бичигт даруй мэдэгдэнэ. Ашиг сонирхол байгааг олон нийтэд нээлттэй мэдээлж болно. Ашиг сонирхлын зөрчил бүрийг зааж өгөх боломжгүй учраас дээрх ашиг сонирхолын зөрчлийн тохиолдлууд нь эцсийнх биш юм. Энд зааснаас бусад болзошгүй өөр тохиолдлуудыг Нарийн бичигт мэдэгдэж, зөвлөгөө авна.

- 6. Төслийн удирдах хороо/ Үнэлгээний Комиссын ёс зүйн код:** Төслийн Удирдах Хороо/ Үнэлгээний Комисс (цаашид Хороо/Комисс гэх) нь судалгааны тэтгэлгийг удирдахдаа үнэнч шударга ёсны зарчмыг баримталж ажиллана. Хороо/Комисс нь судалгааны тэтгэлэгт хөтөлбөрт оролцохыг урих, өргөдөл хүлээн авах, үнэлэх, батлах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Хороо/Комиссын гишүүд судалгааны тэтгэлгийг шударга, үл алагчлах зарчмаар үнэлж, олгосноор олон нийтийн итгэлийг хүлээн, нийтийн эрх ашгийг хамгаалж, Хороо/Комиссын нэр хүндийг худал хуурмаг байдал, авилгал, мэргэжлийн бус үйлдлээс сахин хамгаална. Энэ зорилгоор дараах ёс зүйн стандартыг (i) Төслийн Удирдах Хорооны гишүүд, (ii) Үнэлгээний Комиссын гишүүд, (iii) Судалгааны Төслийн Санал Мэдүүлэгчид мөрдөн ажиллана.

I. Ерөнхий стандарт

Хороо/Комиссын гишүүн:

- (a) Хороо/Комиссийн үйл ажиллагааны нэр хүндийг унагах аливаа үйлээс зайлсхийнэ;
- (b) Хороо/Комиссын өмнө хүлээсэн үүргээ шударгаар биелүүлж, үл алагчилан, субъектив хандлагагүйгээр бодитой үнэлж шийдэхэд саад болох аливаа үйлдлээс зайлсхийнэ. Жишээ нь өргөдөл мэдүүлэгчээс нэмэлт мэдээлэл, тодруулга авахдаа шууд холбогдож, харилцахгүй байх, мөн үнэлгээтэй холбоотой аливаа мэдээллийг задлахгүй байх гэх мэт;
- (c) Хороо/Комиссын үйл ажиллагаатай холбоотой үзэл санаа, журам дүрмийг даган мөрдөх.

Өргөдөл мэдүүлэгч нь:

- (d) Өргөдөл мэдүүлэгчийн үйлдэл нь Хороо/Комиссын нэр хүндийг унагахгүй байх;
- (e) Судалгааны төслийн саналыг үнэлж буй Комиссын гишүүдэд нөлөөлөх зорилгоор тэдэнтэй шууд холбогдохгүй байх;

- (f) Өргөдөл мэдүүлэхтэй холбоотой Хороогоор батлагдсан Судалгааны Тэтгэлэгт Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа удирдамж, журамтай сайн танилцах

II. Тусгай стандарт

Ерөнхий стандартаас гадна дараах тусгай стандартыг баримтална.

(A) Хээль хахууль болон өөртөө ашиглах үйлдэл

(1) Хээл хахуулиас сэргийлэх

Төслийн Удирдах Хорооны зөвшөөрөлгүй сонгон шалгаруулалтыг өөртөө давуу байдлаар ашиглавал, гишүүнийг хээл хахуультай холбоотой үйлдэл хийсэн гэж үзнэ. Хорооны болон Комиссын гишүүд нь мэргэжлийн эрх үүргээ өөрийн хувийн сонирхолд буруугаар ашиглаж, аливаа нэг хүн болон байгууллагад илүү давуу байдлыг өгөхийг хориглоно. Нөгөө талаас өргөдөл мэдүүлэгч нь Хороо болон Үнэлгээний Комиссын гишүүдийн үнэлгээнд нөлөөлөх зорилготой аливаа бэлэг сэлтээр тал засах эсвэл айлган сүрдүүлэх үйлдэл хийхийг хориглоно.

(2) Хүлээн зөвшөөрөх давуу тал

- (a) Хорооны болон Комиссын гишүүнд өгсөн бэлгийг дурсгалын зүйлд тооцож хүлээж авах

Хорооны болон Комиссын аль нэг гишүүнд өгсөн бэлэг дурсгалын зүйлийг Хороо Комиссд өгсөн бэлэг дурсгалын зүйл гэж үзнэ (жишээ нь өргөдөл мэдүүлэгч хүндэтгэлийн арга хэмжээнд Хороо/Комиссын гишүүнийг эсвэл төлөөлөгчийг урьж бэлэг дурсгалын зүйл гардуулах гэх мэт). Бэлэг дурсгалын зүйлийг хүлээж авсан гишүүн дээрх тохиолдолд хүлээж авсан бэлэг дурсгалын зүйлийг Хороонд хүлээлгэн өгөхөөр мэдэгдэнэ.

- (b) Хорооны эсвэл комиссын гишүүний хувьд өгсөн давуу байдал
- (i) Хороо эсвэл комиссын гишүүнд өгсөн зүйлийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрч болох юм
- Уг зүйлийг хүлээж авах нь комиссын гишүүний үнэлгээнд огт нөлөөлөхгүй гэж үзэх;
 - Хороо/Комиссын үйл ажиллагаатай холбоотой ямар нэг зүйлийг хариуд нь хийж өгнө гэсэн шаардлага гарахгүй гэж үзэх
- (ii) Хэрвээ Хороо, Комиссын гишүүн өгсөн зүйлийн хариуд заавал нэг зүйлийг буцааж хийж өгөхөөс аргагүй байдалд орно гэж үзвэл уг зүйлийг хүлээж авахаас татгалзаж байгаагаа илэрхийлнэ.

(B) Ашиг сонирхлын зөрчил

(1) Тодорхойлолт

Хороо/Комиссын гишүүний хувийн эрх ашиг Хороо/Комиссын нийтлэг эрх ашигтай зөрчилдөх тохиолдол ашиг сонирхлын зөрчил үүснэ. “Хувийн ашиг сонирхол”-д Хороо/Комиссын гишүүний хувийн болон түүний гэр бүл, төрөл садан, найз нөхөд, клуб, нийгэмлэг болон түүнээс авлагатай аливаа этгээдийн эрх ашиг багтана.

(2) Ашиг сонирхлын зөрчлийг удирдах

- (a) Ашиг сонирхлын зөрчлийг мэдээлэх хоёр тохиолдол байна. Үнэлгээний Комиссын гишүүнээр томилогдсон даруйдаа болон дахин томилогдох эсвэл нөхцөл өөрчлөгдсөн тохиолдол бүрт стандарт маягтын дагуу ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл хийнэ. “Ашиг сонирхлын бүртгэл”-ийн маягтыг жил бүр бөглөж, шинэчилж өгнө. Хоёр дахь тохиолдол нь, судалгааны саналыг үнэлэх явцад гарсан ашиг сонирхлын зөрчил үүсэх учир шалтгаан гарсан үед мэдэгдэл хийнэ.
- (b) Хорооны гишүүн болон комиссын гишүүн нь аливаа ашиг сонирхлын зөрчилтэй үйлдлээс зайлсхийнэ. Тэд өөрсдийн албан эрх үүргийг эсвэл тэдэнд олдсон мэдээллийг өөрийн хувийн болон нийгмийн холбоотой этгээдэд ашигтай байдлаар хэрэглэхийг хориглоно. Тэд өөрсдийгөө бодит ашиг сонирхлын зөрчилтэй байдал, эсвэл болзошгүй байдалд оруулахаас зайлсхийнэ. Өргөдөл мэдүүлэгчидтэй холбоотой аливаа ашиг сонирхлын зөрчилтэй үйлдлээс зайлсхийж чадаагүй, уг үйлдлийг мэдэгдэж, мэдээлээгүй тохиолдолд эсвэл зөвшөөрөл авалгүй холбоотой өргөдөл мэдүүлэгчийн судалгааны төслийн саналд санал зөвлөмж өгсөн тохиолдолд бусдаас давуу байдал үүсгэж тал зассан, эрх мэдлээ буруугаар ашигласан, авилгал хээл хахуульд холбогдсон гэж буруутгагдаж болно. Тиймээс Хорооны болон Комиссын гишүүд урьдчилан ашиг сонирхлын зөрчлийн болзошгүй нөхцөл байдлыг мэдэгдэх хэрэгтэй.
- (c) Гишүүн ашиг сонирхлын зөрчилтэй болохоо мэдэгдсэн тохиолдолд, тухайн өргөдлийн мэдүүлэгтэй холбоотой асуудлыг хэлэлцэх үед Комиссын дарга гишүүний тухайн хуралд оролцож санал өгч болох эсэх эсвэл ажиглагчаар оролцох эсвэл бүр оролцуулахгүй байхыг шийднэ.
- (d) Өргөдөл мэдүүлэгчид өөрсдийн мэдүүлэгтээ нэр дэвшсэн гишүүдтэй ямар нэг холбоотой эсэх, ашиг сонирхлын зөрчилтэй байж болзошгүй эсэхээ мэдэгдэж, хэрвээ зөрчилтэй бол урьдчилан Төслийн Удирдах Хороонд мэдэгдэнэ.

(3) *Судалгааны төслийн саналыг үнэлсэн комиссын гишүүдийн үнэлгээ*

- (a) Гишүүд нь төслийн саналыг үнэлэхдээ өөрийн хувийн болон байгууллагыг төлөөлөн үнэлгээ хийхгүй цэвэр бие даасан, алагчлал үгүй шударга дүгнэлт байна.
- (b) Гишүүд нь (i) өөрийн байгууллага, хэлтсийн хамт ажилладаг хүний төслийн саналыг үнэлж болохгүй, мөн (ii) сүүлийн 2 жилд ажиллаж байсан байгууллагын эсвэл (iii) өөрөө очиж зөвлөгөө өгч байсан байгууллагын хүмүүсийн төслийн саналыг үнэлж болохгүй. Гишүүнд ашиг сонирхлын ямар нэг эргэлзээ байвал нарийн бичгийн даргад мэдэгдэж, Нарийн бичиг зохих удирдлагаар уг төслийн саналыг дахин хянуулах эсвэл өөр гишүүнээр үзүүлэхийг шийднэ.
- (c) Өргөдөл мэдүүлэгчтэй ижил байгууллагад ажилладаг гишүүн Комиссын хуралд оролцож болох боловч шийдвэр гаргахад оролцохгүй.

Хууль зөрчих

Хорооны болон Комиссын гишүүн мөн өргөдөл мэдүүлэгч нь хувь хүний мэдээллийн нууцлал болон Монголын улсын холбогдох хууль, дүрмийг зөрчих аливаа ёс зүйгүй үйлдэл хийхээс зайлсхийнэ.

Санхүүжилт олгох

Гишүүд нь нийтийн эрх ашгийг хамгаалан хянамгай, хариуцлагатайгаар санхүүжилтийг олгоно. Санхүүжилтийн зориулалтад нийцсэн мөн шалгуур үзүүлэлтийг хангасан судалгааны төслийн саналд

санхүүжилтийг батлан олгоно. Нээлттэй, шударга, өрсөлдөөнт зарчмаар төслийн саналыг үнэлж, хамгийн өрсөлдөхүйц төслийг шалгаруулна.

Судалгааны төслийн саналыг нууцлах

Бүх төслийн санал болон тайланг нууцлалтайгаар үнэлнэ. Комиссын гишүүд үнэлгээний явцал төслийн саналыг агуулгыг аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй. Комиссын гишүүд үнэлгээ дуусасны дараа бүх холбоотой бичиг баримтыг устгана. Шударга байх үүднээс, Комиссын гишүүн төслийн талаарх аливаа нэмэлт мэдээллийг болон үнэлгээний явцын мэдээллийг Гол Судлаачтай шууд холбогдож мэдээлж болохгүй. Гол судлаачтай зөвхөн Нарийн бичгээр дамжуулж холбогдоно.

Хувийн мэдээллийг нууцлах

Судлаачийн талаар болон судалгааны төслийн талаар Комиссын гишүүдийн өгсөн санал сэтгэгдэл нь хувийн мэдээлэл байх талтай. Комиссын гишүүдийн өгсөн санал зөвлөмжийг судлаачид өгөхөөс өмнө ямар Комиссын гишүүн тухайн санал зөвлөмжийг өгснийг нууцалж, ерөнхийд нь Үнэлгээний Комиссын зөвлөмж гэсэн байдлаар судлаачид танилцуулна. Бүх Комиссын гишүүдээс уг төслийн саналд зөвлөмж авч, судалгааг сайжруулахад уг зөвлөмжийг тусгахыг судлаачид зөвлөх бодлогыг Төслийн Удирдах Хорооноос барьж ажиллана.